

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН САЙНШАНД СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
5 ДУГААР СУРГУУЛЬ**

Огноо: 2019.12.12

**ДОРНОГОВЬ АЙМГИЙН САЙНШАНД СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
5 ДУГААР СУРГУУЛЬД “СУРГУУЛИЙН ДОТНО ГАДНА КАМЕРИЙН ӨРГӨТГӨЛ,
БАГШ ХӨГЖЛИЙН ТӨВД ШИРЭЭ САНДАЛ ХУДАЛДАН АВАХ”
АЖЛЫН БАРИМТ БИЧИГ**

Төслийн нэр: “Сургуулийн дотно гадна камерын өргөтгөл, багш хөгжлийн төвийн ширээ
сандал худалдан авах”

Гэрээний дугаар: ХА-2019/01

Сайншанд сум

2019 он

Нэг. Санал авах урилга

Огноо: 2019-12-13

1. **Дорноговь аймгийн Сайншанд сумын ерөнхий боловсролын 5 дугаар сургууль нь** сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос **Дорноговь аймгийн Сайншанд сумын ерөнхий боловсролын 5 дугаар сургуульд** “Сургуулийн дотно гадна камерын өргөтгөл, багш хөгжлийн төвийн ширээ сандал худалдан авах”-д **бараа нийлүүлэх ажлын цахим тендерт** үнийн санал ирүүлэхийг урьж байна.
2. Үнийн санал ирүүлэх ажлын тоо хэмжээ, техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.
3. Тендерийн баримт бичгийг эргэж төлөгдөхгүй нөхцөлтэйгээр иж бүрдлээр нь **50000** төгрөгөөр худалдан авч болно. Тендерийн баримт бичиг худалдан авсан төлбөрийн баримтыг **Дорноговь аймгийн Сайншанд сумын Ерөнхий боловсролын 5 дугаар сургуульд ирүүлснээр** энэхүү тендерт оролцох эрх үүсэх болно. Тендер нь түүнийг нээсэн өдрөөс эхлэн **30** хоногийн дотор хүчинтэй байна.
4. Тендерийн материалыг **2019 оны 12-р сарын 19**-ны өдрийн 10 цаг 30 минутаас өмнө www.tender.gov.mn цахим хуудсаар ирүүлнэ үү.
5. Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан **2019 оны 12-р сарын 19-ний өдрийн 11 цаг 00** минутад нээнэ.
6. **Дотоодын давуу эрх тооцохгүй.**

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Дорноговь аймаг Сайншанд сумын ЕБ-ын 5 дугаар сургууль Утас:70522552 90092728

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- | | | | |
|---|---|-----|---|
| 1 | Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа | 1.1 | Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна. |
| 2 | Тендер ирүүлэх, тендерийн нээлт | 2.1 | Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна. |
| | | 2.2 | Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ. |
| 3 | Тендерийн иж бүрдэл | 3.1 | <p>Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ.</p> <p>ААН байгууллага бол дараах материалуудыг бүрдүүлнэ. Үүнд:</p> <p>(а) Үнийн санал;</p> <p>(б) Компанийн танилцуулга ;</p> <p>(в) Үнийн болон нийлүүлэлтийн хуваарь;</p> <p>(г) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан сүүлийн 1 жил/ болон бусад баримт бичиг;</p> <ul style="list-style-type: none">- Улсын бүртгэлийн гэрчилгээний баталгаажсан хуулбар /Гадаад худалдаа/- Тендерт оролцогчийг төлөөлж гарын үсэг зурсан этгээдийн итгэмжлэл- Харилцагч банкны тодорхойлолт /өргүй байх/ Эх хувь хуулбарласан тохиолдолд нотариотоор батлуулсан байх- Татварын газрын тодорхойлолт /өргүй байх/ Эх хувь хуулбарласан тохиолдолд нотариотоор батлуулсан байх- Нийгмийн даатгалын газрын тодорхойлолт /өргүй байх/ Эх хувь хуулбарласан тохиолдолд нотариотоор батлуулсан байх- Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолт /өргүй байх/ Эх хувь хуулбарласан тохиолдолд нотариотоор батлуулсан байх <p>- Бараа, бүтээгдэхүүний танилцуулга болон фото зураг, техникийн тодохойлолтын хамт /Тодорхойлолтуудыг тендер зарлагдсан өдрөөс ажлын 5 хоногийн өмнөх хоногоос дотогш байна /</p> |
| 4 | Үнийн санал | 4.1 | Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана. |

- | | | | |
|---|---|-----|--|
| 5 | Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд | 5.1 | Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана. |
| | | 5.2 | Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ. |
| 6 | Үнийн саналын хүчинтэй байх хугацаа | 6.1 | Үнийн саналын хүчинтэй байх хугацаа |
| 7 | Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх | 7.1 | Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ. |
| | | 7.2 | Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь ТШӨХ-д заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ. |
| | | 7.3 | Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно. |
| 8 | Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл | 8.1 | Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна. |
| | | 8.2 | Бусад оролцогчдод тэдгээрийн шалгараагүй үндэслэлийг тодорхой тайлбарласан мэдэгдлийг нэгэн зэрэг хүргүүлнэ. |

Гурав.ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	<p>Сүүлийн [1] жилийн санхүүгийн тайлан: 2018 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг аудитын дүгнэлтийн хамт /</p> <p>Бусад нэмэлт шаардлага; /Тодорхойлолтуудыг тендер зарлагдсан өдрөөс хойш он сар өдрөөр ирүүлсэн байх/</p> <p>ААН байгууллага бол дараах материалуудыг бүрдүүлнэ. Үүнд:</p> <p>(а) Үнийн санал;</p> <p>(б) Компанийн танилцуулга ;</p> <p>(в) Үнийн болон нийлүүлэлтийн хуваарь;</p> <p>(г) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан сүүлийн 1 жил/ болон бусад баримт бичиг;</p> <ul style="list-style-type: none"> - Улсын бүртгэлийн гэрчилгээний баталгаажсан хуулбар /Гадаад худалдаа/ - Тендерт оролцогчийг төлөөлж гарын үсэг зурсан этгээдийн итгэмжлэл - Харилцагч банкны тодорхойлолт /өргүй байх/ Эх хувь хуулбарласан тохиолдолд нотариотоор батлуулсан байх - Татварын газрын тодорхойлолт /өргүй байх/ Эх хувь хуулбарласан тохиолдолд нотариотоор батлуулсан байх - Нийгмийн даатгалын газрын тодорхойлолт /өргүй байх/ Эх хувь хуулбарласан тохиолдолд нотариотоор батлуулсан байх - Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын тодорхойлолт /өргүй байх/ Эх хувь хуулбарласан тохиолдолд нотариотоор батлуулсан байх - Бараа, бүтээгдэхүүний танилцуулга болон фото зураг, техникийн тодохойлолтын хамт /Тодорхойлолтуудыг тендер зарлагдсан өдрөөс ажлын 5 хоногийн өмнөх хоногоос дотогш байна /
ТӨӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:</p> <ul style="list-style-type: none"> - Тендер хүлээн авах этгээд: www.tender.gov.mn - Байгууллагын хаяг: Сайншанд сумын Ерөнхий Боловсролын 5-р сургууль - Давхар болон өрөөний дугаар: 2 давхар, 203 тоот - Аймаг, хот: Дорноговь аймаг Сайншанд сум - Огноо: 2019 оны 12 дугаар сарын 19-ний өдөр Цаг: 10 цаг 30 минут
ТӨӨЗ 2.1	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</p> <ul style="list-style-type: none"> - Байшин, гудамжны нэр: Сайншанд сумын ЕБ-ын 5-р сургууль - Давхар болон өрөөний дугаар: 2 давхар, 203 тоот - Аймаг, хот: Дорноговь аймаг Сайншанд сум - Улс: Монгол Улс

	- Тендерийн нээлт хийх огноо, цаг нь: Огноо: 2019 оны 12 дугаар сарын 19-ний өдөр. Цаг: 11 цаг 00 минут.
ТӨӨЗ 6.2	Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: Дорноговь аймгийн Сайншанд сумын Ерөнхий боловсролын 5 дугаар сургуульд тоног төхөөрөмж нийлүүлэх ажлаас бүрдэнэ.

Дөрөв. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

1	Гүйцэтгэх бараа, ажил, үйлчилгээ	1.1	Гүйцэтгэгч барааг гэрээний тусгай нөхцөлд заасны дагуу хийж гүйцэтгэнэ.
2	Ажлын хуваарь	2.1	Гүйцэтгэгч гэрээний тусгай нөхцөл буюу техникийн тодорхойлолт, ажлын даалгаварт заасан хуваарийг чанд мөрдөж ажиллана.
3	Оюуны өмчийн эрх	3.1	Гэрээнд заагдсан бараа, ажил, үйлчилгээг худалдан авах ажиллагаанд оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна.
4	Гэрээнд өөрчлөлт оруулах	4.1	Гэрээний дагуу худалдан авах барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй.
5	Гүйцэтгэлийн хянагч	5.1	Гэрээнд тусгайлан заагаагүй бол гэрээтэй холбогдсон аливаа асуудлыг шийдвэрлэх үүрэг бүхий захиалагчийг төлөөлөн гүйцэтгэлийн хянагч ажиллана.
6	Төлбөр	6.1	Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш 1 хоногийн дотор шуурхай хийнэ.
7	Алданги оногдуулах	7.1	Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн барааны гэрээний үнийн гэрээний тусгай нөхцөлд заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн гэрээний тусгай нөхцөлд заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй.
8	Үүргээ биелүүлээгүйгээс гэрээг цуцлах	8.1	Гүйцэтгэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна.
9	Маргааныг шийдвэрлэх	9.1	Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.
10	Бусад нөхцөл	10.1	Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаатай байна.
		10.2	Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томъёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно.
		10.3	Гүйцэтгэгч ажлын талбай дээрх бүх үйл ажиллагааны аюулгүй байдлыг хариуцна.

Б. ХУГАЦААНЫ БОЛОН ЧАНАРЫН ХЯНАЛТ

- | | | |
|--|------|---|
| 11 Үйл ажиллагааны хөтөлбөр | 11.1 | Гүйцэтгэгч нь бараа нийлүүлэх, ажил гүйцэтгэх, үйлчилгээ үзүүлэхэд шаардлагатай бүх үйл ажиллагааны ерөнхий аргачлал, зохион байгуулалт, дэс дараалал, хугацаа болон бусад шаардлагатай мэдээллийг тусгасан үйл ажиллагааны хөтөлбөрийг боловсруулж, гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд гүйцэтгэлийн хянагчид хүргүүлж батлуулна. |
| 12 Зөрчил, гологдол илрүүлэх | 12.1 | Гүйтгэлийн хянагч гүйцэтгэгчийн үйл ажиллагааг шалгаж, илэрсэн зөрчил, гологдлын талаар мэдэгдэнэ. Энэхүү шалгалт нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Гүйтгэлийн хянагч нь гүйцэтгэж буй аливаа ажилд зөрчил, гологдол хайх, уг ажлын далд хэсгийг нээж шалгалт, туршилт явуулах эрхтэй. |
| 13 Зөрчил, гологдол арилгах | 13.1 | Гүйтгэлийн хянагч гэрээний тусгай нөхцөлд заасан чанарын баталгаат хугацаа ³ дуусахаас өмнө зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдлийг гүйцэтгэгчид өгнө. Чанарын баталгаат хугацааг зөрчил, гологдлыг арилгаж дуусах хүртэл сунгана. |
| | 13.2 | Зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдэл өгсөн тухай бүр гүйцэтгэгч уг зөрчил, гологдлыг гүйцэтгэлийн хянагчийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж өөрийн зардлаар арилгана. |
| 14 Зөрчил, гологдол арилгахгүй байх | 14.1 | Хэрэв гүйцэтгэгч зөрчил, гологдлыг гүйцэтгэлийн хянагчийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж арилгаагүй бол Гүйтгэлийн хянагч зөрчил, гологдол арилгахад шаардагдах зардлыг тооцож гүйцэтгэгчээс гаргуулна. |

В. ГЭРЭЭГ ДУУСГАХ

- | | | |
|--|------|---|
| 15 Гэрээний үүрэг дуусгавар болох | 15.1 | Гүйцэтгэгч нь гэрээний үүргээ хэрэгжүүлж дууссан тухай мэдэгдэл гаргах хүсэлтийг гүйтгэлийн хянагчид хүргүүлэх бөгөөд гүйтгэлийн хянагч ажил дууссан гэж үзвэл уг мэдэгдлийг гаргана. |
|--|------|---|

Тав. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

- ГЕН 1.1 Гэрээний нэр болон бүртгэлийн дугаар: *[Санал авах урилгад заасан нэр болон дугаар]*
- ГЕН 2.1 Гэрээ хэрэгжүүлж эхлэх өдөр: **2019.12.24**
Гэрээг дуусгахаар төлөвлөсөн өдөр: **2019.12.24**
- ГЕН 2.1 Гүйцэтгэгч гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш 7 хоногийн дотор тодотгосон ажлын хөтөлбөрийг гаргана.
- ГЕН 4.1 Гүйцэтгэгч дараахь баримт бичгийг захиалагчид бүрдүүлж өгнө. Үүнд:
[Жагсааж бичих] Тухайлбал:
- 1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;**
 - 2) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт;**
 - 3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;**
 - 4) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;**
 - 5) барааны гарал үүслийн гэрчилгээ.**
 - 6) ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлага**
 - 7) гүйцэтгэлийн зураг гэх мэт**
- ГЕН 6.1 Чанарын баталгаат хугацаа эсхүл баталгаат засварын хугацаа 1 жил ба түүнээс дээш байна.
- ГЕН 7.1 Алданги ногдуулах хэмжээ гэрээнд заасан хугацаа хэтрүүлсэн тал нь хоног тутам гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 0.5 хувь байна
Нийт ногдуулах алдангийн дээд хэмжээ нь гэрээний үнийн дүнгийн **10 хүртэл хувь** байна.

Зургаа. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Багц 1 /Багш хөгжлийн төвийн ширээ сандал/

№	Худалдан авах хөрөнгийн нэрс	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Үзүүлэлт
1	Багш ширээ сандлын ком	ш	38	Ширээний тавцан сайн чанарын модон болон ДСП хавтангаар хийгдсэн байна. Ширээний хөл нь сайн чанарын төмрөөр хийгдсэн, жийргэвч резинтэй байна. Сандал нь 1 комонд 2 ширхэг байх ба түшлэг болон тавцан сайн чанарын зөөлөвч материалтай байна. Баталгаат хугацаа: 1 болон түүнээс дээш жил

Багц 2 /Сургуулийн дотор, гадна камерийн өргөтгөл/

№	Худалдан авах хөрөнгийн нэрс	Хэмжих нэгж	Тоо ширхэг	Үзүүлэлт
1	DVR	ш	5	16 порттой 2 мега пикель унших чадвартай Дэлгэцийн харуулах нягтрал 720
2	Хард диск	ш	4	Багтаамж нь 3 tera byte
3	Гадна камер	ш	10	2 мега пикель унших чадвартай 3.6 мм-ийн зузаан линзтэй
4	Адаптор	ш	20	12V, 2A хүчин чадалтай
5	Дэлгэц	ш	1	40' өнгөт, full HD

Долоо. БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

Нэр	Тодорхойлолт	Хэмжих нэгж	То ширхэг	ГШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цаг	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
					Нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа
1	2	3	4	5	6	7	8
Дорноговь аймгийн Сайншанд сумын ЕБ-ын 5 дугаар сургуульд тоног төхөөрөмж нийлүүлэх ажил					2019.12.24	2019.12.24	

Найм. ЖИШИГ МАЯГТ

1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.

2. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.

3. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Хэмжих нэгж	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БУЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаарахгүй.

№	Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас факс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1					
2					
3					
4					
5					
	Бусад				

Ес. ГЭРЭЭНИЙ МАЯГТ

БАТЛАВ.

ЗАХИАЛАГЧ

НИЙЛҮҮЛЭГЧ

(Тамга, тэмдэг)

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас [захиалагчийн нэр] (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас [нийлүүлэгчийн нэр] (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны __ сарын ____ -ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь [гэрээний нэр, дугаар]-г (цаашид “бараа” гэх) [гэрээний үнийг тоогоор болон үсгээр] (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг _____ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь _____ нэр төрлийн барааг _____ оны __ дугаар сарын ____ -наас _____ оны __ дугаар сарын ____ -ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл

Бусад шаардлагатай баримт бичиг;

Үнийн санал;

Гэрээний тусгай нөхцөл;

Гэрээний ерөнхий нөхцөл;

Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;

Санхүүжилтийн хуваарь.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.

7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.

8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]

[Гарын үсэг] _____

үсэг] _____

ТАМГА

[Захиалагчийн хаяг]

[Утас/факсын дугаар]

[Харилцагч банкны нэр, дансны дугаар]
дугаар]

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]

[Гарын

ТАМГА

[Нийлүүлэгчийн хаяг]

[Утас/факсын дугаар]

[Харилцагч банкны нэр, дансны